




ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 04 дугаар хавсралт



**ТРАСТ ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН  
НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО**

Энэхүү баримт бичиг нь Трaст финанс ББСБ өмч болно.



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 04 дугаар хавсралт

<i>Хамрах хүрээ:</i> Трастфинанс ББСБ	<i>Хариуцах эзэн:</i> ТРАСТФИНАНС ББСБ ХХК дотоод хяналт болон дотоод аудиты газар
<i>Хувийг хадгалах:</i> Гүйцэтгэх захирал	<i>Танилцах:</i> ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг
<i>Хүчинтэй хугацаа:</i> 2023.10.10	<i>Хуудасны тоо:</i> 4


**Өөрчлөлтийн түүх:**

№	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1			
2			
3			
4			
5			
6			
7			

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 04 дугаар хавсралт



## БОДЛОГЫН ТОВЬЁОГ

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ баримт бичгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлно.

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

2.1.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3 Компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

2.2 ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 2.1-т заасан нөхцөл хангагдсан байна.

2.3 Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

2.4 Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

2.5 Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6 ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

2.7 Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

2.8 Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.

2.9 Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.